

Нийслэлийн аудитын газраас өгсөн

зөвлөмжийн хэрэгжилт

- Сүхбаатар дүүргийн 2014 оны нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр зөрчил илэрсэн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын удирдлага болон нягтлан бодогч нарыг нэгбүрчлэн дуудаж уулзан цаашид зөрчил гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан.

- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас зөрчил их хэмжээгээр гаргаж ажлын хариуцлага алдсан 1 дүгээр сургуулийн нягтлан бодогч Гиваасэвжид, Өсвөрийн зохион бүтээх лаборатор ахлах сургуулийн нягтлан бодогч Вандансүрэн нарыг ажлаас халах хүртэл арга хэмжээ авсан.

- Дотоод хяналтын хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн системийн хэрэгжилт, Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх шинэчилсэн журам, анхаарах асуудал зэрэг сэдэвт сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулсан.

- Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл тооцооны алдаа гаргасан зэрэг алдаа зөрчлийн улмаас ЖДҮДТөвийн даргад Засаг даргын захирамжаар сануулах арга хэмжээ авсан.

Зөвлөмж	Хэрэгжилт
Хог тээврийн хураамжийн орлогыг дүүргийн татварын дансаар дамжуулж зарцуулж байх.	Хог тээвэрлэгч Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Алтан дорнын хүч ХХК, ЦҮЗҮКИ ХХК, Улаанбаатар шинэчлэл ХХК зэрэг 5 компанийн хогны орлогыг татварын дансаар дамжуулан эхний 06 сарын сарын байдлаар 712,5 сая төгрөгийн орлого оруулж санхүүжилтийг олгож байна.
Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах.	2014 оны Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147-р тогтоол, 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай Сангийн сайдын 122 дугаар тушаал гарсантай холбогдуулан, 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдөр дүүргийн Засаг

	<p>даргын А-339 дүгээр захирамж тус тус гарсан. Захирамжийн хувийг төсөвт байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор мэдээлэл, сурталчилгааны зардал гаргаагүй болно</p> <p>Байгууллагаас өөрсдийн цахим хаяг болон фэйсбүүк хаягаар иргэдэд мэдээ, мэдээлэл зар, төрийн үйлчилгээг үзүүлэх талаар зөвлөгөөг тухай бүр өгч ажиллаж байна. Ингэснээр шуудан харилцаа холбооны зардлыг тодорхой хувиар бууруулж байна.</p> <p>Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай А/34 дүгээр захирамж Засаг даргын Тамгын газраас Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-тйа 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах тухай 13 дугаар гэрээгээр Хороодын байрны харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ зэргийг гэрээний үндсэн дээр Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлж байна.</p> <p>2015 оны 02 дугаар сараас үйлчилгээний ажилтнуудын орон тоог 53%-иар бууруулсан.</p>
<p>Санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж байх.</p> <p>Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг</p>	<p>Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан</p>

<p>үнэн зөв мэдээллээр хангаж байх.</p>	<p>дансны заавар, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал-ын дагуу тайлагнаж байна.</p>
<p>Орлогыг санхүүгийн тайланд бүрэн үнэн зөв тусгаж байх.</p>	<p>ЖДҮДТөв. ИТХ-ын нягтлан бодогч нар орлогыг дутуу болон буруу тусгасныг анхааруулж цаашид нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болголоо.</p>
<p>Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах.</p>	<p>2014 онд 25-р сургууль 630,0 мянган төгрөг, 130-р цэцэрлэг 50,0 мянган төгрөгөөр төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь урьд оны авлагыг барагдуулаад хоол болон бусад зардлыг санхүүжүүлсэн зөрчил гарсан үүнийг 2015 онд дахин давтахгүйгээр төсвийн хуваарийг баримтлан гүйлгээг хянаж хийж байна.</p>
<p>Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооц нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулж байх.</p>	<p>Нягтлан бодогч нарын дунд сургалт зохион байгуулан тайлангаар гарсан зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар заавар зөвлөгөөг өглөө.</p>
<p>Хоол унааны хөнгөлөлтөөс татварыг зөв суутган тооцож байх.</p>	<p>Төлбөр тооцооны мэргэжилтэн нар цалингаас суутгасан суутгалыг хянаж гүйлгээ хийж байна.</p>
<p>Илүү олгосон цалин хөлсийг суутган төвлөрүүлэх.</p>	<p>Хүүхэд, гэр бүл хөгжлийн төвийн ажиллагсдын цалинд илүү олгосон 4511,1 мянган төгрөгний акт тогтоосноос 2352,0 мянган төгрөгийг барагдуулсан.</p>

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.МӨНХЗУЛ